



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 17 өдөр

Дугаар A/07

Улаанбаатар хот

Аж ахуйн гэрээ байгуулах, дүгнэх журам
батлах тухай

Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.10 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аж ахуйн гэрээ байгуулах, дүгнэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг Гэрээ, борлуулалтын инженер Б.Батцоожид үүрэг болгосугай.
3. Журмыг холбогдох албан тушаалтнуудад танилцуулахыг Гэрээ, борлуулалтын инженер Б.Батцоож, компанийн цахим хуудсанд байршуулж мэдээллэж ажиллахыг Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч Ш.Отгонбаярмаа нарт тус тус даалгасугай.
4. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /Б.Ган-Очир/ –т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ

Амгалан дулааны станц ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2020 оны.....дүгээр сарын
17-ны өдрийн А/ОТ.....дугаар тушаалын хавсралт



АЖ АХУЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

1.1 Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах, хамтарч ажилладаг талуудтай гэрээ байгуулах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК”-ийн хэмжээнд аж ахуйн гэрээ байгуулах, бүртгэх, хэрэгжилтийг хангах, түүний биелэлтэнд хяналт тавих, дүгнэх үйл ажиллагаанууд хамаарна.

ГУРАВ. БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ

3.1 Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

ДӨРӨВ. ХАМААРАХ ТАЛУУД

4.1 Компанийн бүх алба, хэлтэс, цех, хэсгүүдэд хамаарна.

ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭМЖҮҮР

Гүйцэтгэлийн хэмжүүр	Хэмжих аргачлал	Өгөгдлийн эх үүсвэр	Давтамж
Гэрээний гүйцэтгэлийн түвшин	Гүйцэтгэл хангагдаагүй гэрээний тоо/нийт гэрээний тоо	Гэрээний судалгааны дүгнэлт	Жил бүр
Гэрээний хариуцлага тооцолт	Ногдуулсан алданги м.төг/Алданги тооцсон гэрээний тоо	Гэрээний биелэлтийн тайлан	Хугацаанаас хамаарч

ЗУРГАА. БАРИМТ БИЧГИЙН НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

6.1. “Гэрээ” гэдэг нь хоёр буюу хэд хэдэн этгээд тодорхой асуудлаар бие биедээ буюу гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн үүрэг хүлээх талаар тохиролцож, хуулийн дагуу

үйлдсэн бичиг баримтыг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.

“Гэрээний баримт бичиг” гэж Гэрээний маягтанд (хийсэн өөрчлөлтүүдийн нь хамт) дурьдсан баримт бичгүүдийг хэлнэ.

“Гэрээний үнэ” гэж Гэрээнд (Гэрээний үнэ) заасан, Гэрээний дагуу нэмэгдэж, хасагдаж эсвэл тохируулга хийгдэж болох дүнг хэлнэ.

“Төлбөрийн нөхцөл” гэж Гэрээнд заасан Төлбөр хийх нөхцөл ба журамд заасны дагуу төлбөр хэрхэн төлөхийг заасныг хэлнэ

“Захиалагч” гэж Гэрээнд бараа, ажил, үйлчилгээг захиалсан гэрээнд захиалагч гэж нэрлэгдсэн этгээдийг мөн түүний хууль ёсны эрх залгамжлагч буюу орлох этгээдийг хэлнэ.

“Гүйцэтгэгч” гэж Гэрээний дагуу үүрэг гүйцэтгэхийг Захиалагчаас хүлээн зөвшөөрсөн Гэрээнд Гүйцэтгэгч гэж нэрлэгдсэн, хууль ёсны эрх залгамжлагчтай эсвэл түүнийгээ томилсон этгээдийг хэлнэ.

“ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ.

“ГТН” гэж Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ.


“Гэрээний хугацаа” гэж гэрээнд заасан бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх, төлбөр төлөх, бараа, ажил, үйлчилгээг хүлээлцэх, гэрээ дүгнэх үйл ажиллагааны хугацааг талууд харилцан тохиролцож тогтоосон хугацааг хэлнэ.


6.2. Товчилсон нэрийн жагсаалт

№	Товчилсон нэр	Тайлал
1	“АДС” ХХК	Амгалан дулааны станц-Хязгаарлагдмал хариуцлагатай компани
2	ЗУХ	Захиргаа удирдлагын хэлтэс
3	СЭЗХ	Санхүү эдийн засгийн хэлтэс
4	ИХ	Инженерийн хэсэг
5	ДА	Дотоод аудитор
6	ХХ	Хяналтын хэсэг
7	ААХА	Аж ахуй хангамжийн алба
8	АХ	Автын хэсэг
9	ЗЦ	Зуухан цех
10	ТДЦ	Түлш дамжуулах цех
11	НЦ	Нэгдсэн цех
12	ЦХ	Цахилгааны хэсэг
13	ДХХА	Дулааны хянах хэмжүүр автоматик
14	ХиХ	Химийн хэсэг
15	ТУСПИ	Технологи удирдлагын системийн программист инженер

ДОЛОО. ҮНДСЭН ХЭСЭГ

7.1 Процессын урсгал диаграм





7.2 Процессын алхамын тайлбар

Процессын нэр	Процессын алхам
А. Гэрээ байгуулах	
Гэрээ байгуулах шийдвэр авах	Аж ахуйн бүх төрлийн гэрээг байгуулах үндэслэл нь тухайн жилийн бизнес төлөвлөгөөнд хөрөнгө нь тусгагдаж батлагдсан байх ба гэрээний төслийг санаачлагч нь тухайн гэрээтэй холбогдоотой хянаж батлагдсан зураг, төсөв, тендерийн үнэлгээний хорооны зөвлөмж болон бусад холбогдох материалыг бүрдүүлэн Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, холбогдох Дэд захирал, холбогдох алба, хэлтэс, хэсэг, цехийн дарга нараас санал авч компанийн гүйцэтгэх захиралд танилцуулж зөвшөөрөл авсан байна.
Гэрээ байгуулахад шаардагдах өгөгдөл цуглуулах	<ul style="list-style-type: none"> ✓ Гэрээ байгуулах талаар хүсэлт гаргасан албан бичиг ✓ Байгууллагын гэрчилгээний хуулбар ✓ “Тусгай зөвшөөрөл”-ийн гэрчилгээний хуулбар ✓ Тендерийн баримт бичиг ✓ Үнэлгээний хорооны зөвлөмж ✓ Уг бараа, ажил, үйлчилгээний хөрөнгийн эх үүсвэр /бизнес төлөвлөгөө, төсөв, зураг/ зэрэг материалыг цуглуулж авна.
Гэрээний төсөл боловсруулах, санал авах	Гэрээний төслийг гэрээ байгуулах санал гаргасан холбогдох мэргэжлийн ажилтан гэрээ, борлуулалтын инженер, боловсруулах ба гэрээний төсөлд талуудын холбогдох ажилтнуудаас цаасаар санал авна.
Гэрээний төсөлд өгсөн саналыг хянах, нэмэх	Гэрээний төсөлд талуудын ирсэн саналыг оруулах эсэхийг холбогдох нэгжтэй гэрээ, борлуулалтын инженер зөвшилцөн хянаж, үл нийцэх саналыг буцаах, нийцэх саналыг нэмж тусган гэрээний төслийг эцэслэн гаргана.
Гэрээ байгуулах этгээдтэй санал солилцох	Гэрээ байгуулах этгээдэд гэрээний төсөл танилцуулж эцсийн байдлаар харилцан зөвшилцөж тохиролцоно.
Гэрээг хэвлэх, баталгаажуулах	<ol style="list-style-type: none"> 1. Бэлэн болсон гэрээг шаардлагатай хувиар хэвлэх 2. Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна. /хасвралт №02/
Гэрээг бүртгэж, дугаар өгөх, шилэн дансанд оруулах	Баталгаажсан гэрээнд Захирлын туслах дугаар өгч, гэрээний бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ. 4. Холбогдох албан тушаалтан шилэн дансанд оруулна.
Батлагдсан гэрээг тараах	Батлагдсан гэрээний хувийг талуудын холбогдох ажилтнуудад хүлээлгэн өгнө.
Б. Гэрээ дүгнэх	
Гэрээ дүгнэхэд	✓ Гэрээт ажлын төсөв, төсвийн гүйцэтгэл

шаардагдах материал цуглуулах	<ul style="list-style-type: none"> ✓ Ажил хүлээлцсэн акт, их засвараас хүлээн авсан акт, бараа материал хүлээн авсан комиссын акт, орлогын баримт, гүйцэтгэлийн зураг, схем, ажлын тайлан ✓ Санхүүтэй тооцоо нийлсэн акт ✓ Бараа материалын чанарын сертификат, шинжилгээний бичиг, гарал үүслийн бичиг, техникийн тодорхойлолт, СХЗГ-аар баталгаажуулсан гэрчилгээ зэрэг материалыг бүрдүүлж авна. ✓ Гэрээнд заагдсан бусад шаардлагатай материалууд./тоног төхөөрөмжийн үйлдвэрийн баталгаа, угсралтын баталгаа г.м/
Гэрээ дүгнэсэн актын төсөл бичих	Дээрх материалуудыг үндэслэн гэрээ дүгнэсэн актын төслийг холбогдох мэргэжлийн ажилтан боловсруулж гэрээ, борлуулалтын инженер хянана.
Гэрээ дүгнэсэн актын төсөлд талуудын санал авах	Гэрээ дүгнэсэн актын төсөлд талуудын санал авна.
Гэрээ дүгнэсэн актын төсөлд өгсөн саналыг хянах, нэмэх	Гэрээ дүгнэсэн актын төсөлд ирсэн саналыг оруулах эсэхийг хянаж, үл нийцэх саналыг буцаах, нийцэх саналыг нэмж тусган гэрээ, борлуулалтын инженер эцэслэн гаргана.
Гэрээ дүгнэсэн актыг хэвлэх, баталгаажуулах	<ol style="list-style-type: none"> 1. Гэрээ дүгнэсэн актыг шаардлагатай хувиар хэвлэх 2. Гэрээ дүгнэсэн актанд талуудын гарын үсгийг зуруулна.
Гэрээг хаах	Гэрээ дүгнэсэн актыг үндэслэн гэрээний бүртгэлийн журналд гэрээний гүйцэтгэлийг гэрээ, борлуулалтын инженер бичиж хаана
Гэрээний материалыг архивын нэгж болгон архивлах	<ol style="list-style-type: none"> 1. Хавтаст байгаа дүгнэгдсэн гэрээнүүдийг үдээсийг авч, хуудсыг дугаарлана 2. Гэрээний материалыг боть болгон товъёог бичиж, үдэж хавтаслан, хаяглана 3. Үдсэн материалыг архивт баримт хүлээлгэн актын дагуу хүлээлгэн өгнө.

7.3 Үндсэн шаардлага

7.3.1. Гэрээ байгуулах санал гаргасан **холбогдох** этгээд болон Гэрээний **инженер** нь компанийн хэмжээнд байгуулах гэрээний төслийг боловсруулахдаа Иргэний хуульд заасны дагуу дараахи нөхцлүүдийг заавал тусгасан байна. Үүнд:

1. Гэрээний үндэслэл (хуульд заасан гэрээнд зайлшгүй тусгавал зохих, түүнчлэн гэрээ байгуулагч талуудын аль нэг нь хуулийн хүрээнд хүссэний дагуу нөгөө тал нь зөвшөөрсөн нөхцлийг/
2. Гэрээ байгуулагч талуудын харилцан хүлээх үүрэг, эдлэх эрх
3. Гэрээний үнийн талаар
4. Мөнгөн төлбөрийн хэлбэр, түүнийг гүйцэтгэх арга, хугацаа
5. Гэрээний үүргийн биелэлтийг хангах арга
6. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс үүсэх хариуцлагын талаар

7. Гэрээний хугацаа, түүнийг сунгах, эсэх асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар
8. Гэрээг өөрчлөх ба цуцлах үндэслэлийн талаар
9. Гэрээний үүргийг биелүүлэх талаар гарсан маргаан шийдвэрлэх талаар гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулиар тогтоосон журамд нийцсэн байх
10. Гэрээ байгуулагч талуудын байгууллагын байршил, албан ёсны нэр, хаяг, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гэрчилгээний хуулбар, гэрээ байгуулагч талууд болон тэдгээрийн аль нэг нь хуулийн этгээд бол түүнийг төлөөлөн гэрээ байгуулж байгаа хүний овог нэр, албан тушаал, ажлын болон гар утасны дугаар, хувь хүнтэй гэрээ байгуулахад түүний иргэний үнэмлэх, регистрийн дугаар, ажлын болон гэрийн хаяг, гар утасны дугаар.
11. Хийсэн ажил, нийлүүлсэн тоног төхөөрөмж, сэлбэг материалын баталгаат хугацааг тодорхойлж, өөрийн зардлаар дахин хийх, шинээр сольж өгөх талаар.
12. Хугацаа хоцроосон буюу хэтрүүлсэн хоногийн алдангийн хэмжээг тооцох.
13. Бараа материал, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлэх, суурилуулах, угсрах, СХЗГ-аар баталгаажуулах талаар тодорхой тусгах.
14. Гэрээнд тусгасан техникийн тодорхойлолт, тусгай нөхцлийн заалтуудыг зөрчихгүй, өөрчлөхгүй байх нөхцөл бүрдсэн байна.
15. Зарлагдсан тендерийн нэрийг дахин өөрчлөхгүй байх.

7.3.2. Гэрээ дүгнэсэн актанд дараахи нөхцлийг заавал тусгана. Үүнд:

1. Гэрээгээр гүйцэтгэсэн бараа, ажил, үйлчилгээний хэмжээ, хугацаа, хэрэв хугацаа хоцроосон болон хэтэрсэн бол шалтгаан, алдангийн тооцоо.
2. Гэрээг бараа, ажил үйлчилгээний чанар байдал, баталгаат хугацаа, гомдлын шаардлагын талаар
3. Гэрээгээр гүйцэтгэсэн бараа, ажил үйлчилгээний үнийн дүн, урьдчилгаа төлбөр, үлдэгдэл төлбөрийг төлөх хугацааг тодорхой зааж өгөх
4. Гэрээ хэрэгжих явцад гарсан асуудал, нэмэлт өөрчлөлт хийсэн эсэх талаар

НАЙМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

8.1 Санхүү, Эдийн Засгийн Хэлтэс

- 8.1.1 Аж ахуйн гэрээний зардал бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан эсэхийг хянана.
- 8.1.2 Бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч гэрээ хийх зайлшгүй шаардлагатай зардлын эх үүсвэрийг шийдвэрлэнэ.
- 8.1.3 Аж ахуйн гэрээний нэгдсэн бүртгэл судалгааг хөтөлж, гэрээний хугацаанд хяналт тавих, гэрээтэй холбоотой мэдээллээр хангана.

8.2 Алба, хэлтэс, цех хэсгийн удирдлага

- 8.2.1 Аж ахуйн гэрээ байгуулах үндэслэл, саналаа удирдлагуудад танилцуулж, гэрээ байгуулах зөвшөөрөл авна.
- 8.2.2 Хийгдэж байгаа аж ахуйн гэрээ, түүний нөхцөл нь хууль тогтоомж дүрэм журамд нийцүүлж боловсруулах.
- 8.2.3 Аж ахуйн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.

ЕС. ХАРИУЦЛАГА

Энэхүү журмын заалтыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу Гүйцэтгэх захирлын тушаалаар хариуцлага хүлээлгэнэ.

**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ ГЭРЭЭ
БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ АЛБАН ТУШААЛТАН**

Хавсралт №02

№	Гэрээний төрөл	Гэрээ байгуулах, гэрээ дүгнэсэн актыг хянаж гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан	Гэрээний төсөл бэлтгэх, гэрээ дүгнэсэн акт боловсруулах албан тушаалтан
1	Бараа, материал, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдах, худалдан авах гэрээ	Гүйцэтгэх захирал, Аж ахуй эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Аж ахуй хангамжийн албаны дарга, холбогдох алба, хэлтэс, цехийн дарга, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Аж ахуй хангамжийн албаны дарга, хангамжийн ажилтан, инженер нар
2	Үндсэн ба туслах тоноглолын их ба урсгал засварын ажил гүйцэтгэх гэрээ	Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, холбогдох дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, холбогдох цехийн дарга, инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Холбогдох цехийн дарга, инженер
3	Деталь хийц захиалгаар хийлгэх, засварлуулах, хийцийн ажлын гэрээ	Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Холбогдох цехийн дарга, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Холбогдох цехийн дарга, инженер
4	Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ /УБДС ТӨХК/	Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Санхүү эрхэлсэн дэд захирал, Инженерийн хэсгийн дарга, инженер, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Горимын хяналт, тооцооны инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Горимын хяналт, тооцооны инженер, Гэрээ, борлуулалтын инженер.
5	ЦЭХ худалдах, худалдан авах /Цахилгаан, дулааны эрчим	Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Санхүү эрхэлсэн дэд захирал,	, Горимын хяналт, тооцооны инженер, Гэрээ, борлуулалтын инженер.

	хүчний диспетчерийн хийх/гэрээ	Үйлдвэрлэлд зохицуулалт	Инженерийн хэсгийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Горимын хяналт, тооцооны инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Цахилгааны инженер
6	Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээ /УСУГ/		Гүйцэтгэх захирал, Инженерийн хэсгийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Горимын хяналт, тооцооны инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	, Горимын хяналт, тооцооны инженер, Гэрээ, борлуулалтын инженер. Барилга, сантехникийн инженер
7	ДЭХ хэрэглэгч аж ахуйн нэгж байгууллагуудтай хийх гэрээ		Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Санхүү эрхэлсэн дэд захирал, Инженерийн хэсгийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Горимын хяналт, тооцооны инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Горимын хяналт, тооцооны инженер, Гэрээ, борлуулалтын инженер
8	Сургалт, дадлагын гэрээ		Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, ЗУХ-ийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Сургалт, судалгааны мэргэжилтэн, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Сургалт, судалгааны мэргэжилтэн
9	Банк, санхүү, даатгалын үйл ажиллагаатай холбоотой гэрээ		Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч,
10	Түрээсийн болон түрээслэх гэрээ		Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн дэд захирал болон Аж ахуй эрхэлсэн дэд захирал, Аж ахуй хангамжийн албаны дарга, холбогдох албаны инженер, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Аж ахуй хангамжийн албаны дарга, холбогдох мэргэжлийн ИТА
11	Төмөр замтай холбоотой гэрээнүүд		Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Санхүү эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга	Түлш дамжуулах цехийн дарга, инженер Гэрээ, борлуулалтын инженер.

			бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, ТДЦ-ийн дарга, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	
12	Нүүрс худалдах, худалдан авах гэрээ		Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, ТДЦ-ийн дарга, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Гэрээ, борлуулалтын инженер.
13	Барилгын засварын ажил гүйцэтгүүлэх гэрээ		Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн дэд захирал, Аж ахуй эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Аж ахуй хангамжийн албаны дарга, Барилга, сантехникийн инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Барилга, сантехникийн инженер
14	Гэрээт галын хэсэг ажиллуулах гэрээ, ОБГ-тай хамтран ажиллах гэрээ, Галын багаж хэрэгсэл худалдан авах гэрээ		Гүйцэтгэх захирал, Аж ахуй эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Аж ахуй хангамжийн албаны дарга, ХАБЭА-н инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	ХАБЭАИ нар
15	Эмнэлэг, сувилал, эм эмнэлгийн хэрэгслэлийн үйлчилгээ үзүүлж хамтран ажиллах гэрээ		Гүйцэтгэх захирал, Аж ахуй эрхэлсэн дэд захирал, ЗУХ-ийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Их эмч, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Хүний нөөцийн менежер, ХАБЭАИ нар
16	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хүлээн авах, устгах гэрээ		Гүйцэтгэх захирал, Аж ахуй эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Аж ахуй хангамжийн албаны дарга, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Аж ахуй хангамжийн албаны дарга.
17	СХЗГ-тай хамтран ажиллах гэрээ		Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Холбогдох хэсэг, алба, цехийн дарга, ДХХА-ийн инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	ДХХА-ийн инженер

18	Хамгаалалтын гэрээ	Гүйцэтгэх захирал, Аж ахуй эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, ААХА-ны дарга, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Аж ахуй хангамжийн албаны дарга
19	Орон сууц худалдах, худалдан авах гэрээ, Газар худалдан авах гэрээ, Ажилтнуудтай хийх орон сууцны гэрээ	Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн дэд захирал, ЗУХ-ийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, ААХА-ны дарга, Барилга, сантехникчийн инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Аж ахуй хангамжийн албаны дарга, Хуулийн мэргэжилтэн.
20	Хөлсөөр ажил гүйцэтгүүлэх гэрээ	Гүйцэтгэх захирал Санхүү эрхэлсэн дэд захирал, ЗУХ-ийн дарга, ЗХН-ийн мэргэжилтэн, СЭЗХ-ийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, Холбогдох алба, хэлтэс, цехийн дарга, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Хариуцсан нэгжийн удирдлага
21	Туршилт, судалгааны ажил гүйцэтгэх гэрээ	Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, холбогдох дэд захирал, холбогдох алба, хэлтэс, цехийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Холбогдох алба, хэлтэс, цехийн дарга нар
22	Тусгай зөвшөөрөл, төсөл, хөтөлбөрийн гэрээ	Гүйцэтгэх захирал, Тэргүүн дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Санхүү эрхэлсэн дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер., холбогдох цехийн дарга нар.	Холбогдох алба, хэлтэс, цехийн дарга нар
23	Дотоод орлого бүрдүүлэх гэрээ	Гүйцэтгэх захирал, Холбогдох дэд захирал, холбогдох алба, хэлтэс, цехийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Холбогдох алба, хэлтэс, цехийн дарга нар

24	Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, хор саармагжуулах бүтээгдхүүн худалдан авах гэрээ	Гүйцэтгэх захирал ,Холбогдох дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, ХАБЭА-н инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	ААХА-ны дарга,
25	Үйлчилгээ үзүүлэх гэрээ	Гүйцэтгэх захирал ,Холбогдох дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	ААХА-ны дарга,
26	Газар шороо, зам засварын гэрээ	Гүйцэтгэх захирал ,Холбогдох дэд захирал, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Барилга, сантехникийн инженер, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	ААХА-ны дарга,
27	Бусад гэрээнүүд	Гүйцэтгэх захирал ,Холбогдох дэд захирал, холбогдох алба, хэлтэс, цехийн дарга, СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Хуулийн мэргэжилтэн, Гэрээ, борлуулалтын инженер.	Холбогдох алба, хэлтэс, цехийн дарга нар